

## БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР:

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны даргын эрхлэх асуудлын хүрээнд Биеийн тамир, спортын салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад төсөвт өртөг нь 162,0 тэрбум төгрөг, санхүүжих дүн 48,8 тэрбум төгрөг бүхий 35 төсөл, арга хэмжээ батлагдсан.

Монгол Улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Аймаг, нийслэл, дүүрэгт усан сан бүхий спортын ордон барих ажлыг үргэлжлүүлж ажлын, дугуйн болон гүйлтийн зам, мөсөн гулгуурын талбай шинээр барьж хүн бүр биеийн тамир, спортоор хичээллэх, хот, суурин газар, байгууллага, хамт олон, өрх гэр бүлд эрүүл амьдралын орчин нөхцөлийг бүрдүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх,” бодлогын хүрээнд Нийслэлийн Баянзүрх, Налайх дүүргийн спорт цогцолборын барилгын ажлыг эрчимжүүлж, аймгийн төвүүдэд наадмын талбайг сэргээн засварлах, шинээр барих, хөл бөмбөгийн талбайг орчин үеийн стандартын дагуу барьж байгуулах ажлууд хийгдээд байна.

2023 онд Биеийн тамир, спортоор хичээллэх нөхцөлийг хангах зорилгоор аймаг, нийслэлийн хэмжээнд томоохон усан бассейн бүхий спорт цогцолборын барилга, спортын ордон зэрэг барилга байгууламжийг ашиглалтад оруулаад байна. Тухайлбал: Улаанбаатар хотын Налайх дүүргийн 700 хүний суудалтай спорт цогцолборын барилга, Говь алтай аймгийн Есөн булаг сумын цэнгэлдэх хүрээлэнгийн барилга, Баянхонгор аймгийн Шинэжинст сумын спорт заалны барилга, Ховд аймгийн Зэрэг сумын спорт заалны барилга, Увс аймгийн Хяргас сумын спорт заалны барилга зэргийг бүрэн ашиглалтад оруулаад байна.

Тайлант онд улсын төсвөөс 21 барилга байгууламжийн 32,230.9 сая төгрөгийн санхүүжилтийг авч зарцуулсан ба мөн 14 барилга байгууламжийг эрх шилжсэн хөрөнгө оруулалтаар 16,587.4 сая төгрөг, нийт 35 барилга байгууламжид 48,818.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг зарцуулаад байна.

### БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

<i>Хүснэгт</i>	<i>гүйцэтгэл жилийн эцсээр /сая.төг/</i>					
Хөрөнгө оруулалт	2022 онд			2023 онд		Батлагдсан төсвийн өсөлт
	2022 Санхүүжих дүн	Гүйцэтгэл	Хувь	2023 Санхүүжих дүн	Гүйцэтгэл	
	46,983.6	35,163.3			48,823.2	

<b>Шилжих барилга</b>	38,909.9	27,246.9	70.0	<b>48,823.2</b>	48,818.3	1,839.6
<b>Шинэ барилга</b>	7,303.0	<b>7,297.6</b>	99.9	-	-	-
<b>Их засвар /шинэ/</b>	670.7	<b>618.8</b>	92.3			
<b>Тоног төхөөрөмж</b>	100.0	<b>0</b>				
<b>ТЭЗҮ</b>	100.0	<b>0</b>	0			

Хүснэгтээс харахад 48,823 тэрбум төгрөг төсөвлөснөөс 2023 оны жилийн эцэст 48,813.3 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан байна. Төсөвлөснөөс шилжих барилга 2023 онд 99.98 хувийн гүйцэтгэлтэй хийгдсэн.

1. Улаанбаатар хотын Налайх дүүргийн 700 хүний суудалтай спорт цогцолборын барилга – Төсөвт өртөг 15,0 тэрбум төгрөг

Тэнхлэгээрээ 67.7 м х 51 м хэмжээтэй, зоорьтой, 3 давхар, 36 м х 30 м хэмжээтэй спорт заал, 25 м х 11 м хэмжээтэй сэлэлтийн 4 замтай усан бассейн барилга бүхий томоохон спорт цогцолбор юм. 2023 оны 12 дугаар сарын байдлаар барилга угсралтын ажил дуусах шатандаа бөгөөд Улсын комисс ажиллуулахаар хүсэлт хүргүүлээд байна.



2. Говь алтай аймгийн Есөн булаг сумын цэнгэлдэх хүрээлэнгийн барилга - Төсөвт өртөг 7,0 тэрбум төгрөг

2500-3000 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэнгийн барилгын угсралтын ажлыг 2019 онд “Арвин бэлт” ХХК нь гүйцэтгэгчээр шалгарч, гэрээ байгуулан гүйцэтгэж 2023 оны 07 дугаар сард Улсын комисс ажиллаж, ашиглалтад хүлээн авсан.





3. Спорт заалны барилга, 500 суудал /Ховд, Зэрэг сум/-төсөвт өртөг 3,4 тэрбум төгрөг

Барилга нь тэнхлэгээрээ 48.0 м х 24.0 м хэмжээтэй, зоорьгүй, 2 давхар, барилгын хэмжээ  $S=26304$  м<sup>2</sup>

Барилга угсралтын ажлыг 2021 онд эхэлсэн бөгөөд гүйцэтгэгчээр Ховд аймгийн “Баруун жонон” ХХК шалгарч гэрээ байгуулан гүйцэтгэж 2023 оны 08 дугаар сард ашиглалтад бүрэн хүлээлгэн өгсөн.



4. Спорт заалны барилга /Баянхонгор, Шинэжинст сум/- төсөвт өртөг 881,0 сая төгрөг

Тэнхлэгээрээ 30.0мх15.0м хэмжээтэй, заалны барилгыг 2021 онд эхэлсэн бөгөөд гүйцэтгэгчээр Баянхонгор аймгийн “Буян арвижих од” ХХК шалгарч гэрээ байгуулан гүйцэтгэж, 2023 оны 09 дүгээр сард ашиглалтад хүлээлгэн өгсөн.



5. Спорт заалны барилга /Увс, Хяргас сум/- төсөвт өртөг 2,535.5 сая төгрөг

Тэнхлэгээрээ 18.0 м х 40.0 м хэмжээтэй, зоорьгүй барилга, Барилга угсралтын ажлыг 2021 онд эхэлсэн бөгөөд гүйцэтгэгчээр Увс аймгийн “Мана оюу увс” ХХК шалгарч, гэрээ байгуулан гүйцэтгэж, 2023 оны 12 дугаар сард ашиглалтад орсон.

